Д. Доржоо сонгосон
ХААА-н захиргаа баталгаа
2022. 11. 23 нд

БАТЛАВ.
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНГӨН-ЭРДЭНЭ

ЗУНЫ НИЙЛЭГ ХАЛЬСАН ХҮЛЭМЖ ХУДАЛДАН АВАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2022.11.23 Мөрөн

Үндэслэл: Алсын хараа 2050, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.3 дахь заалт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XVII.3.20 Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл (Хөвсгөл)- хүрээнд хийгдэж буй ажил

Зорилго: Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд дотоодын үйлдвэрлэлээр хүн амын хүнёний хэрэгцээг хангах зорилгоор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд иргэдийн санал санаачилга, хөдөлмөр зүтгэл, идэвх оролцоог нэмэгдүүлэх.

Бараа техникийн тодорхойлолт, стандартын шаардлага				
Бараа бүтээгдэхүүний техникийн үзүүлэлт	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Хөрөнгийн эх үүсвэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалт "Шинэ хөдөө төсөл"			
Төсөвт өртөг	45.000.000 /Дөчин таван сая төгрөг/			
Тоо хэмжээ, зориулалт	6*10 хэмжээтэй дуслын усалгааны системтэй зуны нийлэг хальсан хүлэмж 9 ширхэг.Нэг бүрийн үнэ 5000.000 нийт дүн 45.000.000			

4. Зуны нийлэг бүхий нийлэг хальсан хүлэмжийн иж бүрдэл /6х10/

- Хүлэмжний төрөл: Нийлэг хальсан бүрхүүлтэй, нуман оройтой, хавар-зун-намар ашиглагдах, хүнсний ногоо, жимс, цэцэг, эмийн ургамал тариалах, мод үржүүлгийн ажил хийх боломжтой хүлэмж байна.
- Хэмжээ: Өргөн нь 6 метр, урт нь 10 метр, өндөр нь 2.8 метрээс доошгүй, 60м2 талбайтай байна.
- Иж бүрдэл: Хүлэмжийн цайрдсан ган хоолой бүхий их бие, нийлэг хальсан бүрхүүл, тэдгээрийг холбох, бэхлэх зориулалтын /нийлэг хальс түгжигч, түгжигчийг холбогч, нийлэг хальс хавчигч, хоолой холбогч, хоолой бэхлэгч г.м/ хэрэгслүүдтэй байна.
- Их бие буюу нуман нурууны хоолой нь 1.5мм буюу түүнээс дээш ханын зузаантай, диаметр нь 25мм буюу түүнээс дээш, зэвэрдэггүй, цайрдсан гангаар

хийгдсэн байна. Хөндлөн бэхэлгээний болон суултаас хамгаалсан ган хоолойнууд нь 1.2мм буюу түүнээс дээш ханын зузаантай, диаметр 25 мм буюу түүнээс дээш зэвэрдэггүй, цайрдсан гангаар хийгдсэн байна. Цайрын хэмжээ 300г/м2-аас доошгүй байна.

- Босоо нуман тулгууруудын хоорондох зай: 0.7 метрээс ихгүй байх ба хүчтэй салхинаас хамгаалагдсан хөндлөн бэхэлгээ нуруу 7 эгнээнээс доошгүй, ташуу бэхэлгээ 4 ширхэгээс багагүй, нийлэг хальстай байх үед 25 см-ээс доошгүй зузаантай цас, 25 м/сек-ээс доошгүй хурдтай салхийг тэсвэрлэдэг байна.
- Салхивч ба хаалга: Хүлэмжийн 2 хажуу талд уртын дагуу 0.8 метрээс багагүй 1.2 метрээс ихгүй өргөнтэй агааржуулалтын салхивчтай байна. Салхивчийг нээж, хаах механик төхөөрөмжөөр тоноглосон байна. Хүлэмжийн нэг талдаа хос хаалгатай, шулуун ховилтой замаар роликоор гүйж нээгдэж хаагддаг байна.
- Дээвэр болон хажуу талыг хучих нийлэг хальс: -40-өөс +50 хэмд физик шинж чанараа алддаггүй, 0.1 мм-ээс дээш зузаантай, ашиглалтын хугацаа 3 жилээс доошгүй хүлэмжийн зориулалттай байна. Энэхүү нийлэг хальс нь 5 давхраат бүтэцтэй (хэт ягаан туяаны хамгаалалттай, дулаан барих чадвартай, усан дусал үүсгэдэггүй), нарны гэрэл сайн нэвтэрдэг, тунгалаг, полиолефин (PO) нийлэг хальс байна. Салхины даац 15 кг/м2-аас багагүй байна.

5. Дараах үзүүлэлт бүхий дуслын усалгааны 9 ширхэг иж бүрдэл
- Усалгааны төхөөрөмжийн төрөл: Хамгаалагдсан хөрсний дуслын усалгааны төхөөрөмж
- Услах тармилын төрөл: Хүлэмжийн хүнсний ногоо, жимс
- Услах талбайн хэмжээ: 60м^2 талбай буюу 10 м-ийн урттай, 6 метрийн өргөнтэй талбай байна.
- Тариалалтын схем: 50 см /мөр хоорондын зай/ * 20см /дуслуур хоорондын зай/ схемтэй 8-10 эгнээтэй байна.
- Иж бүрдлүүд: Шүүлтүүр, крант, түгээх болон дуслын услуур бүхий усалгааны хоолой, тэдгээрийг холбогч бэхлэгч дамжуулагч, таглагч цоологч жийргэвч зэрэг эд ангиудтай байна. Эд ангиудын тоо хэмжээг нь ирүүлнэ.
- Дуслын услуур бүхий усалгааны хоолой: Мөрөөр тариалагдах хүлэмжийн хүнсний ногоо услах зориулалтын, 4.0 кг/см^2-аас доошгүй даралтыг тэсвэрлэх чадвартай, ажиллах даралт 0.5кг/см^2, нэг дуслуурын усны зарцуулалт 1.0-1.5 литр/цаг, дотоод диаметр 16.0-18.0мм, ханын зузаан 0.3мм-ээс доошгүй, ашиглалтын хугацаа 2 жилээс багагүй байна.
- Шүүлтүүр крант: Түргэн цэвэрлэгч кранттай, шүүлтүүр нь дискэн, шүүгч торны хэмжээ 0.125 мм-ээс дээшгүй байна.
6. Дагалдах багаж, сэлбэг 9 ширхэг хүлэмжинд
Үйлдвэрлэгчийн стандартын дагуу дагалдах сэлбэг, хүлэмж угсрахад зайлшгүй шаардагдах багаж, температур, агаарын харьцангуй чийг хэмжигч, нарны гэрэл бууруулагч тортой байна.

Жич: Нийлүүлэгчийн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв гэдгийг нотлох зорилгоор үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан

каталог, танилцуулга, зураг, туршилт шинжилгээ, судалгааны дүн, хавсаргаж ирүүлсэн байна.

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮХҮА-НЫ ДАРГА Б.ЦОЛМОНБАЯР

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.ЧИНЗОРИГ

ХЯНАСАН:
ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Я.ЭРХЭМБАЯР

ХЯНАСАН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОЮУНТУЯА